

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Боловсролын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2025/98/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Дундговь аймаг

2025 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох  
Утас: 70592439  
Цахим хаяг: [Munkhtogtokhr@audit.gov.mn](mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn)

Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ  
Утас: 70592225  
Цахим хаяг: [oyun-erdenet@audit.gov.mn](mailto:oyun-erdenet@audit.gov.mn)

Ахлах аудитор: Д.Ихбаяр  
Утас: 70593113  
Цахим хаяг: [Ikhbayard@audit.gov.mn](mailto:Ikhbayard@audit.gov.mn)

Аудитыг гүйцэтгэсэн: Си Пи Ти Эй Аудит  
ХХК Утас: 77233030  
Цахим хаяг: [info@cptaaudit.mn](mailto:info@cptaaudit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

1015.02.15 № 62  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН ДАРГА  
Ц.УРАНБЯМБА ТАНАА**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймаг дахь Боловсролын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Боловсролын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад нийт зардал өмнөх оноос 1.9 дахин өссөн байна. Энэ нь тайлант онд боловсролын байгууллагуудын албан хаагч нарын тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 817,652.3 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг 2,793,432.0 мянган төгрөгийг тус байгууллагын төсөвт тусган зарцуулсантай холбоотой байна. Мөн 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчдын цалин нэмэгдэж, орон нутгийн нэмэгдлийг 20 хувиар тооцож олгох болсонтой холбоотой цалингийн зардал 183,260.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

**Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй

4825020175

болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дундговь аймгийн Боловсролын газар нь 1 хөтөлбөр, 2 арга хэмжээний гүйцэтгэл 96.6 хувьтай, байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 6 зорилт 47 арга хэмжээг хэрэгжүүлж ажилласнаар гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 87.7 хувиар үнэлсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

**Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>37,297,742.31</u></b>	<b><u>29,867,287.37</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	7,902,271.33	3,963,956.33
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	7,902,271.33	3,963,956.33
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	7,902,271.33	3,963,956.33
31218	Ахмадын сангийн харилцах	7,902,271.33	3,963,956.33
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	532,990.94	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	182,990.94	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	350,000.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	350,000.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	28,862,480.04	25,903,331.04
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	7,097,221.04	7,440,221.04
35110	Тусгай зориулалттай материал	7,097,221.04	7,440,221.04
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	21,765,259.00	18,463,110.00
35410	Бичиг хэргийн материал	6,935,985.00	4,021,685.00
35420	Аж ахуйн материал	12,946,574.00	12,893,775.00
35430	Сэлбэг хэрэгсэл	48,500.00	16,500.00
35450	Барилгын засварын материал	1,834,200.00	1,531,150.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>590,572,772.10</u></b>	<b><u>575,799,705.02</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	590,572,772.10	575,799,705.02
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	560,770,938.76	545,967,705.02
39201	Барилга, байгууламж, орон сууц	520,630,937.04	520,630,937.04
39202	Хуримтлагдсан элэгдэл	(53,679,539.87)	(62,929,693.19)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,600,000.00	33,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(20,160,000.00)	(26,880,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	194,733,021.30	218,354,136.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	(118,364,790.99)	(139,213,131.87)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,098,407.64	37,098,407.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	(33,087,096.36)	(34,693,632.59)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	692.85
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(11.16)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	29,801,833.34	29,832,000.00
39301	Програм хангамж	977,890.00	1,097,890.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(888,056.66)	(977,890.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	29,712,000.00	29,712,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>627,870,514.41</u></b>	<b><u>605,666,992.39</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>49,777.47</u></b>	<b><u>7,361,965.31</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	49,777.47	7,361,965.31
<b>413</b>	<b>Өглөг</b>	49,777.47	7,361,965.31
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	6,287,665.31
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	49,777.47	66,300.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	1,008,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,008,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>627,820,736.94</u></b>	<b><u>598,305,027.08</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	627,820,736.94	598,305,027.08

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	387,540,211.70	387,540,211.70
51101	Өмч: - төрийн	387,540,211.70	387,540,211.70
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	94,439,525.41	64,923,815.55
51210	Өмнөх үеийн үр дүн	94,439,525.41	94,472,733.40
51220	Тайлант үеийн үр дүн	-	(29,365,926.91)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	145,840,999.83	145,840,999.83
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>627,870,514.41</u></b>	<b><u>605,666,992.39</u></b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,464,878,077.79</b>	<b>4,613,581,219.85</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>127,250,500.79</b>	<b>25,462,692.85</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	127,250,500.79	25,462,692.85
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	127,250,500.79	25,462,692.85
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,748,295.43	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,840,885.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	123,502,205.36	121,259,219.65
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,337,627,577.00</b>	<b>4,588,118,527.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,091,025,900.00	4,447,824,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,091,025,900.00	4,447,824,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	246,601,677.00	140,293,727.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	194,804,400.00	-
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	-	16,090,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,133,650.00	91,218,127.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,282,527.00	22,256,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,381,100.00	10,729,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,447,108,457.12</b>	<b>4,643,130,137.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,447,108,457.12</b>	<b>4,643,130,137.70</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	875,573,465.80	861,854,397.60
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	402,360,508.08	585,621,456.15
210101	Үндсэн цалин	234,769,354.42	324,743,764.88
210102	Нэмэгдэл	89,712,554.24	160,563,184.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	49,793,896.07	48,388,197.58
210104	Урамшуулал	28,084,703.35	51,926,309.50
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх</b>	49,761,924.58	72,293,775.00

	<b>ШИМТГЭЛ</b>		
210201	Тэтгэврийн даатгал	34,247,307.59	50,451,175.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,957,967.20	5,460,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,166,373.70	2,730,299.52
210204	Ажилгүйдлийн даатгал	762,752.45	2,730,300.48
210205	Эрүүл мэндийн даатгал	7,627,523.64	10,921,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	31,210,869.48	35,286,730.52
210301	Гэрэл, цахилгаан	2,576,329.48	2,337,737.00
210302	Түлш, халаалт	26,822,280.00	29,683,100.52
210303	Цэвэр, бохир ус	1,812,260.00	3,265,893.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	100,935,435.41	21,303,309.00
210401	Бичиг хэрэг	1,829,100.00	10,751,900.00
210402	Тээвэр, шатахуун	3,551,599.95	8,297,660.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	687,100.10	539,650.00
210404	Ном, хэвлэл	-	120,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,077,430.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	865,000.00
210408	Бараа материал акталсны зардал	-	729,099.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	93,790,205.36	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,836,600.00	1,624,550.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,966,000.00	-
210604	Урсгал засвар	870,600.00	1,624,550.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	11,466,670.00	3,108,200.00
210702	Дотоод албан томилолт	11,466,670.00	3,108,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,351,900.00	10,153,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,351,900.00	10,153,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	268,649,558.25	132,462,576.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,263,950.00	10,777,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	210,160,991.00	83,170,002.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37,224,617.25	38,514,874.93
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,571,534,991.32	3,781,275,740.10
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,520,176,041.00	3,628,686,746.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	641,144,458.00	817,652,346.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	878,710,083.00	2,793,432,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	321,500.00	17,602,400.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	21,840.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	21,840.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	51,358,950.32	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,324,914.32	-
213404	Хөрөнгийн	34,036.00	-

<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	152,567,154.10
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	152,567,154.10
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>17,769,620.67</b>	<b>(29,548,917.85)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	1,810,201.27	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,810,201.27	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(1,810,201.27)	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>15,959,419.40</b>	<b>(29,548,917.85)</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,464,878,077.79</b>	<b>4,613,581,219.85</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>127,250,500.79</b>	<b>25,462,692.85</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	127,250,500.79	25,462,692.85
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	127,250,500.79	25,462,692.85
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,748,295.43	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,840,885.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	123,502,205.36	121,259,219.65
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,337,627,577.00</b>	<b>4,588,118,527.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,091,025,900.00	4,447,824,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,091,025,900.00	4,447,824,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	246,601,677.00	140,293,727.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	194,804,400.00	-
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	-	16,090,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,133,650.00	91,218,127.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,282,527.00	22,256,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,381,100.00	10,729,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,447,108,457.12</b>	<b>4,643,130,137.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,447,108,457.12</b>	<b>4,643,130,137.70</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	875,573,465.80	861,854,397.60
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	402,360,508.08	585,621,456.15
210101	Үндсэн цалин	234,769,354.42	324,743,764.88
210102	Нэмэгдэл	89,712,554.24	160,563,184.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	49,793,896.07	48,388,197.58
210104	Урамшуулал	28,084,703.35	51,926,309.50
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	49,761,924.58	72,293,775.00

210201	Тэтгэврийн даатгал	34,247,307.59	50,451,175.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,957,967.20	5,460,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,166,373.70	2,730,299.52
210204	Ажилгүйдлийн даатгал	762,752.45	2,730,300.48
210205	Эрүүл мэндийн даатгал	7,627,523.64	10,921,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	31,210,869.48	35,286,730.52
210301	Гэрэл, цахилгаан	2,576,329.48	2,337,737.00
210302	Түлш, халаалт	26,822,280.00	29,683,100.52
210303	Цэвэр, бохир ус	1,812,260.00	3,265,893.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	100,935,435.41	21,303,309.00
210401	Бичиг хэрэг	1,829,100.00	10,751,900.00
210402	Тээвэр, шатахуун	3,551,599.95	8,297,660.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	687,100.10	539,650.00
210404	Ном, хэвлэл	-	120,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,077,430.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	865,000.00
210408	Бараа материал акталсны зардал	-	729,099.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	93,790,205.36	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,836,600.00	1,624,550.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,966,000.00	-
210604	Урсгал засвар	870,600.00	1,624,550.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	11,466,670.00	3,108,200.00
210702	Дотоод албан томилолт	11,466,670.00	3,108,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,351,900.00	10,153,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,351,900.00	10,153,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	268,649,558.25	132,462,576.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,263,950.00	10,777,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	210,160,991.00	83,170,002.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37,224,617.25	38,514,874.93
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,571,534,991.32	3,781,275,740.10
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,520,176,041.00	3,628,686,746.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	641,144,458.00	817,652,346.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	878,710,083.00	2,793,432,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	321,500.00	17,602,400.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	21,840.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	21,840.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	51,358,950.32	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,324,914.32	-
213404	Хөрөнгийн	34,036.00	-
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт,</b>	-	152,567,154.10

	<b>шилжүүлэг</b>		
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	152,567,154.10
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>17,769,620.67</u></b>	<b><u>(29,548,917.85)</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	1,810,201.27	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,810,201.27	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(1,810,201.27)	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>15,959,419.40</u></b>	<b><u>(29,548,917.85)</u></b>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	387,540,211.70	145,840,999.83	79,740,513.01	613,121,724.54
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-1,260,407.00	-1,260,407.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>387,540,211.70</b>	<b>145,840,999.83</b>	<b>78,480,106.01</b>	611,861,317.54
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	15,959,419.40	15,959,419.40
C08	<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>387,540,211.70</b>	<b>145,840,999.83</b>	<b>94,439,525.41</b>	627,820,736.94
D01	<b>2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>387,540,211.70</b>	<b>145,840,999.83</b>	<b>94,439,525.41</b>	627,820,736.94
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	33,207.99	33,207.99
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>387,540,211.70</b>	<b>145,840,999.83</b>	<b>94,472,733.40</b>	627,853,944.93
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00

D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-29,365,926.91	-29,365,926.91
D09	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>387,540,211.70</b>	<b>145,840,999.83</b>	<b>65,106,806.49</b>	598,488,018.02

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	4,447,824,800.00	4,295,257,645.90
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	683,925,100.00	683,857,899.90
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	546,066,200.00	546,066,199.90
210101	Үндсэн цалин	316,451,700.00	314,574,623.63
210102	Нэмэгдэл	160,156,200.00	131,177,069.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,337,100.00	48,388,197.58
210104	Урамшуулал	38,121,200.00	51,926,309.50
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	68,258,200.00	68,258,200.00
210201	Тэтгэврийн даатгал	46,415,600.00	46,415,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,460,700.00	5,460,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,730,300.00	2,730,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,730,300.00	2,730,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,921,300.00	10,921,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	35,303,300.00	35,303,300.00
210301	Гэрэл, цахилгаан	4,407,400.00	2,337,737.00
210302	Түлш, халаалт	27,646,800.00	29,699,670.00
210303	Цэвэр, бохир ус	3,249,100.00	3,265,893.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,063,500.00	14,063,500.00
210401	Бичиг хэрэг	1,108,700.00	3,683,000.00
210402	Тээвэр, шатахуун	11,695,200.00	8,090,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	150,000.00	539,650.00
210404	Ном, хэвлэл	121,600.00	663,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	653,200.00	1,087,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,854,100.00	3,854,100.00
210604	Урсгал засвар	3,854,100.00	3,854,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,108,200.00	3,108,200.00
210702	Дотоод албан томилолт	3,108,200.00	3,108,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	416,800.00	416,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	416,800.00	416,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	12,854,800.00	12,854,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,468,700.00	4,468,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,386,100.00	8,386,100.00

<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	3,763,899,700.00	3,611,399,746.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	3,763,899,700.00	3,611,399,746.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	912,360,200.00	817,652,346.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	2,851,224,100.00	2,793,432,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	315,400.00	315,400.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	4,447,824,800.00	4,295,257,645.90
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	4,447,824,800.00	4,295,257,645.90
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,447,824,800.00	4,295,257,645.90

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>140,271,887.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>140,271,887.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	123,041,887.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	32,684,600.00
210101	Үндсэн цалин	3,298,485.00
210102	Нэмэгдэл	29,386,115.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	4,085,575.00
210201	Тэтгэврийн даатгал	4,085,575.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	8,729,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,729,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	77,542,712.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	77,542,712.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	17,230,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	17,230,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,230,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>21,840.00</b>
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	21,840.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	140,293,727.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	140,293,727.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	16,090,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	91,218,127.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,256,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,729,000.00

**Гурав. Аудитын илрүүлэлт:** /Илрүүлсэн буруу илэрхийллийн товч утга, түүнийг шийдвэрлэсэн байдал /хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал, залруулсан алдаа, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж/

Аудитаар нийт 10,408.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, аудитын явцад 183.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 5,812.6 мянган төгрөгийн 3 акт тогтоож, 4,413.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлсэн.

#### **Залруулагдсан алдаа:**

Үр дүнгийн тайланд 183.3 мянган төгрөгийн цалин хөлсийг илүү тайлагнасан алдааг илрүүлсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" гэсэн зарчим зөрчигдөж үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад алдааг илрүүлж үр дүнгийн тайланг залруулсан.

#### **Залруулагдаагүй алдаа:**

##### **3.1 Төлбөрийн акт**

1. Томилолтоор ажилласан ажилтанд 960.0 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлт давхардуулан олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т /*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах*/, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т /*Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*/, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2-т /*Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ: 2.2.1. унааны зардал; 2.2.2. байрны зардал; 2.2.3. хоолны зардал*/ заасныг тус тус зөрчиж нийцсэн бөгөөд зохимжтой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
1. Хууль эрх зүйн үндэслэлгүй шийдвэрээр төсвийн шууд захирагчид 4,618.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг бусад урамшуулалтай давхардуулан олгосон зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23.2.-т /*Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно.*/, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д /*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*/, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3-т /*хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох*/ заасныг тус тус зөрчиж нийцсэн бөгөөд зохимжтой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Хувь хүмүүст олгосон олимпиад, уралдаан тэмцээний шагнал, урамшууллын зардлаас 234.0 мянган төгрөгийн албан татвар суутгаж төсөвт төвлөрүүлээгүй. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 9 дугаар зүйл: Татвар ногдуулах орлого тодорхойлох: 19.1.1./*урлаг, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал болон тэдгээртэй адилтгах бусад орлогод албан татвар ногдуулах орлогыг тухайн орлогын дүнгээр*/; 21.2.2.энэ хуулийн 19.1.1-д заасан /*орлогын дүнд 5 хувиар*/ заасныг тус тус зөрчиж нийцсэн бөгөөд зохимжтой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **3.2 Албан шаардлага**

Нягтлан бодогчийн ажлыг улирал бүр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч ажлын байрны тодорхойлолтод заагдсан санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаж, зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр 4,413.0 мянган төгрөгийн урамшуулал давхардуулан олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д /*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*/, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-д /*улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох*/ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д /*Төсвийн байгууллага, төрийн болон орон*

*нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:/ 15.1.3.-д /хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох/; Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2-т заасныг тус тус зөрчиж нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үр дүнгийн тайланд цалин хөлсийг илүү тайлагнасан.	1	183.0	1	183.0			1	183.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>183.0</b>	<b>1</b>	<b>183.0</b>			<b>1</b>	<b>183.0</b>			-	-

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Томилолтоор ажилласан ажилтанд хоолны мөнгө давхардуулан олгосон.	1	960.0	1	960.0								
Хууль эрх зүйн үндэслэлгүй шийдвэрээр төсвийн шууд захирагчид мөнгөн урамшууллыг бусад урамшуулалтай давхардуулан олгосон	1	4,618.6	1	4,618.6								
Хувь хүмүүст олгосон олимпиад, уралдаан тэмцээний шагнал, урамшууллын зардлаас 2албан татвар суутгаж төсөвт төвлөрүүлээгүй.	1	234.0	1	234.0								
Нягтлан бодогчийн ажлыг улирал бүр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч ажлын байрны тодорхойлолтод заагдсан	1	4,413.0			1	4,413.0						

санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаж, зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр урамшуулал давхардуулан олгосон.													
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>10,225.6</b>	<b>3</b>	<b>5,812.6</b>	<b>1</b>	<b>4,413.0</b>		-	-	-	-	-	-

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			